



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот

“Аялал жуулчлал ба ажил эрхлэлт-2014”  
хөдөлмөрийн яармаг зохион байгуулах  
тухай

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3, 3.2.2 дахь заалт,  
Нийслэлийн Аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний  
3.4.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аялал жуулчлалын салбарын боловсон хүчнийг бэлтгэх, ажлын  
байраар хангах зорилготой “Аялал жуулчлал ба ажил эрхлэлт” хөдөлмөрийн  
яармагийг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, шаардагдах  
төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Хөдөлмөрийн яармагийн төсөв болох 432.500 /дөрвөн зуун гучин  
хөёр мянга таван зуу/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч  
/П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.


Гурав. Хөдөлмөрийн яармагийг удирдамжид заасан хугацаанд зохион  
байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг дотоодын аялал жуулчлал хариуцсан  
мэргэжилтэн /Н.Алтанзаяа/-д даалгасугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2014 оны 4 сарын 28-ний өдрийн  
Аял тоот тушаалын нэгдүгээр хавсралт



**“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ БА АЖИЛ ЭРХЛЭЛТ-2014”  
ХӨДӨЛМӨРИЙН ЯАРМАГИЙН УДИРДАМЖ**

**Зорилго:**

Аялал жуулчлалын салбарт ажиллах сонирхолтой оюутан залуус, идэвхтэй ажил хайгч иргэдийг эзэмшсэн мэргэжлийн дагуу түр болон байнгын ажлын байртай болох нөхцөлийг хангах, аялал жуулчлалын байгууллагуудад шаардлагатай байгаа мэргэжлийн ажилтнаа олоход нь дэмжлэг үзүүлэх, ажил олгогч хөдөлмөр эрхлэгчдийг холбоход энэхүү арга хэмжээний зорилго оршино.

**Болох газар:**

Нийслэлийн Засаг захиргааны 4-р байрны 2-р давхар буюу “Улаанбаатар Бизнес хөгжлийн төв”-ийн үзэсгэлэнгийн танхимд

**Хугацаа:**

2014.04.17-ны Пүрэв гараг

**Оролцох аж ахуйн нэгжүүд:**

Тур оператор, жуулчны бааз, зочид буудал, дэн буудал, амралтын газар, зоогийн газар бусад аялал жуулчлалтай холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагууд

**Хамрах хүрээ:**

Аялал жуулчлалын их, дээд сургуулийн оюутнууд  
Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний мэргэжлээр төгсөгчид  
Ажил идэвхтэй хайж буй иргэд

**Ерөнхий зохион байгуулагчид:**

Нийслэлийн Аялал жуулчлалын газар  
Нийслэлийн Хөдөлмөрийн газар

**Хамтран зохион байгуулагчид:**

Аялал жуулчлалын үндэсний төв  
Монголын Аялал жуулчлалын холбоо  
Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн төв  
Аялал жуулчлалын багш, судлаачдын нийгэмлэг

**Зохиогдох үйл ажиллагаа:**

- 2014 оны аялал жуулчлалын улиралд салбарын байгууллагуудад хэрэгцээтэй байгаа ажлын байрыг нийтэд зарлах
- Ажил олгогч болон нээлттэй ажлын байрны зар мэдээллийг түгээх, сурталчлах
- Аялал жуулчлалын салбарын ажил мэргэжлийн онцлог, шаардагдах мэдлэг ур чадваруудын талаарх видео хичээл, танилцуулгыг хийх


**Санхүүжилт:**

Үзэсгэлэн зохион байгуулах танхимын түрээсийг Нийслэлийн Хөдөлмөрийн газар, бусад шаардлагатай зардлыг Нийслэлийн Аялал жуулчлалын газар хариуцна. Оролцогч, үзэгчид нь аливаа хэлбэрээр төлбөр, хураамж төлөхгүй.

**Бүртгэл:**

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дэргэдэх Аялал жуулчлалын мэдээлэл, сурталчилгааны төв (Бага тойруу-15 Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Нийслэлийн Засаг захиргааны 4-р байр хуучнаар Улаанбаатар банкны байрны Баруун хойд талын хаалга) Холбоо барих утас: 70108687, 7012-8687, 96076064, 18001896

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2014 оны 04 сарын 08 ний өдрийн  
01/04 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ БА АЖИЛ ЭРХЛЭЛТ-2014”  
ХӨДӨЛМӨРИЙН ЯАРМАГ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Гадна болон дотор байрлуулах анонс хэвлүүлэх	2	30000	60.000
2	Стэнд тус бүрийн хаяг хэвлүүлэх /хөмсөг/	50	1000	50.000
3	Цэвэр ус /10л/	3	2500	7.500
4	Нэг удаагийн аяга	300	50	15.000
5	Видео шторк хийлгэх	1	300.000	300.000
	<b>Нийт дүн</b>		<b>432.500</b>	

БОЛОВСРУУЛСАН:

ДОТООДЫН АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖИЛТЭН

Н.АЛТАНЗАЯА

ХЯНАСАН:  
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

П.АРИУНАА

“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ БА АЖИЛ ЭРХЛЭЛТ-2014”  
ХӨДӨЛМӨРИЙН ЯАРМАГИЙН ТОВЧ ХӨТӨЛБӨР

10.00 Хөдөлмөрийн яармагийн албан ёсны нээлт /Хөтлөгч Д.Мөнхтөмөр/  
Нээлтэд оролцох албаны хүмүүсийг индэр дээр урина. /Хөтлөгч Д.Мөнхтөмөр/  
Нээлтэд уригдах хүмүүс:

- Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Э.Баттулга
- Нийслэлийн Хөдөлмөрийн газрын дарга Н.Тунгалаг
- ССАЖЯ-ны Аялал жуулчлалын үндэсний төвийн хэлтсийн дарга Э.Батзаяа
- Монголын Аялал жуулчлалын холбооны менежер Б. Бүжинлхам
- Аялал жуулчлалын тогтвортой хөгжил төвийн менежер Б.Цэнгэлмаа

10:10 – 10:20 Хөдөлмөрийн яармагийг нээж Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Э.Баттулга, Нийслэлийн Хөдөлмөрийн газрын дарга Н.Тунгалаг нар үг хэлнэ.

10:20-11:30 Хамтран зохион байгуулж буй байгууллагуудын танилцуулга явах

11:30 – 16:00 “Аялал жуулчлал ба ажил эрхлэлт-2014” хөдөлмөрийн яармагийн үйл ажиллагаа үргэлжилнэ.

16:00- 16:30 Ажил олгогч байгууллагууд нэгдсэн дүнгээ зохион байгуулагч нарт өгнө.

16:30-16:35 Нийслэлийн Аялал жуулчлалын газрын

.....“Аялал жуулчлал ба ажил эрхлэлт”

хөдөлмөрийн яармагийг хаана.

Жич: Нээлтийн дараагаас үзэсгэлэнг дуусах хугацааг хүртэл оролцогч байгууллагуудын танилцуулгыг дэлгэцээр гаргах